



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

IV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 17:30 цагт Төрийн ордон дахь "Их Эзэн Чингис хаан" танхимд 85 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Нийслэлийн хэмжээнд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболдын мэдээллийг сонсов.
2. Бусад.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат.

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян.

Нийслэлийн Онцгой комиссын дарга Д.Сумъяабазар нарт:

1.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлж, эрүүл мэндийн байгууллага, эрдэмтдийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүдэд:

2.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног

төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг тооцож, бэлэн байдлыг хангуулах, хүний нөөцийн судалгааг гаргах;

2.2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх, хязгаарлалтын дэглэм тогтоох үеийн ач холбогдлыг мэдээлж ойлгуулах;

2.3. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн яам, Шуурхай штаб, нийслэлийн Онцгой комисс хамтран боловсруулж батлуулах;

2.4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийслэлийн хүн амын дунд тандалт, судалгаа хийх зорилгоор дүүрэг, хорооны иргэд, айл өрх, албан байгууллагыг хамруулж, зохион байгуулалтын өндөр түвшинд өргөн цар хүрээтэй зохион байгуулж, дүнг танилцуулах;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

3.1. Нийслэлийн хэмжээнд тогтоосон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийслэлээс гарах, орох чиглэлийн зорчигч тээврийн хөдөлгөөнийг бүрэн хязгаарлах;

3.2. Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирээд хязгаарлалтын дэглэмд орсон иргэдийг PCR шинжилгээний хариуг үндэслэн нутаг буцаах ажлыг 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийг дуустал шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулах.

ДАРГА
С.АМАРСАЙХАН
УХА0158
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ДЭД ХУРАНДАА
Т.МӨНХДОРЖ